



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
“БАЯНТЭЭГ” ХУВЬЦААТ ҚОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 04 сарын 03 өдөр

Дугаар 01

Баянтээг


Г Компанийн 2019 оны үйл ажиллагааны түүхийн
болов санхүүгийн тайлангийн тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалтыг үндэслэн “Баянтээг” Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:

“Баянтээг” Хувьцаат Компанийн гүйцэтгэх захирлын хэлэлцүүлсэн 2019 оны жилийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хангалттай сайн гэж үзсүгэй.

ХУРЛЫН ДАРГА:

/О.БАТЖАРГАЛ/





ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
“БАЯНТЭЭГ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 04 сарын 03 өдөр

Дугаар 02

Баянтээг

Г Т
Аудитын байгууллагын дүгнэлтийг сонсох
тухай

Компанийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 6 дэх хэсгийн 2 дэх заалтыг
үндэслэн “Баянтээг” Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас
ТОГТООХ нь:

“Баянтээг” ХК-ийн 2019 оны Санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын
байгууллагын тайланг, сонсож сайшаасугай.

ХУРЛЫН ДАРГА:



/О.БАТЖАРГАЛ/



БАЯНТЭЭГ ХК-ИЙН
ЗАХИРАЛ О.СУМЬЯАСҮРЭН-д

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,
Утас/Факс: (976) 7032 3253,
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

2020. 03. 11 № 105
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баянтээг ХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянтээг ХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянтээг ХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглувансан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бэгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланда тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Баянтээг ХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аudit хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланда санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ

АУДИТОР

Л.ЛАМААЧИН





ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
“БАЯНТЭЭГ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 04 сарын 03 өдөр

Дугаар 03

Баянтээг

Г ТУЗ болон Гүйцэтгэх захирлын
зардлын төсвийн тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 13 дах заалтыг үндэслэн
“Баянтээг” Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:

- “Баянтээг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалинг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тогтоож, ТУЗ-ийн хуралд оролцсон ирцийг харгалзаж олгосугай.
- Гүйцэтгэх захиралтай ТУЗ-ийн байгуулсан гэрээний дагуу 2020 оны үндсэн цалинг 2.650.000 төгрөгөөр, 2019 оны урамшууллыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 260 дугаар тогтоолыг үндэслэн олгосугай.
- Цаашид гүйцэтгэх удирдлага, удирдлагын багийн урамшууллыг Аймгийн ИТХ-аар баталсан журмын дагуу шийдвэрлэж байхыг үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА:

/О.БАТЖАРГАЛ/





ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
“БАЯНТЭЭГ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 04 сарын 03 өдөр

Дугаар 04

Баянтээг

Г Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
гишүүдийг батлах тухай

7

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дах заалтыг удирдлага болгон Тооллогын комиссын дүн, тогтоолыг үндэслэн “Баянтээг” Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. “Баянтээг” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүдээр

- 1) Д.Нэмэхбаяр
- 2) Г.Баясгалан
- 3) М.Нинжбадгар
- 4) Б.Ичинноров
- 5) Ц.Болдбаатар
- 6) Д.Миеэгомбо
- 7) Ю.Батсайхан

2. “Баянтээг” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдээр

- 1) Ц.Оюун
- 2) Л.Жаргалбаатар
- 3) З.Дашзвэг
- 4) С.Эрдэнэ

нарыг тус тус Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдээр сонгогдоноыг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА:



/О.БАТЖАРГАЛ